
The background features a bright blue sky with several light blue, stylized clouds scattered across the top and middle sections. At the bottom, there is a white silhouette of a city skyline with various building shapes, including a prominent skyscraper with vertical lines. The overall aesthetic is clean and modern.

**Угсарсан нийлмэл үгийг ялган  
таньж, эх өгүүлбэрт гүйцэтгэсэн  
найруулгын үүргийг  
тодорхойлох**

# Хичээлийн зорилго


- Эх ба өгүүлбэрээс нийлмэл үгийг ялган таних
- Нийлмэл үгийн бүтсэн арга, хоорондын зэрэгцэх ба угсрах харьцааг ажиглах, тайлбарлах
- Угсарсан нийлмэл үгийн бүтсэн аргыг мэдэх
- Өгүүлбэрт ямар утга, үүрэгтэй байгааг тодорхойлох



# Нийлмэл үг гэж юу вэ?

Хоёр бие даасан үг зэрэгцэх ба угсрах харьцаагаар нийлж үг бүтээх аргыг үг нийлэх арга гэдэг. Энэ аргаар бүтсэн үгийг нийлмэл үг гэнэ.

Жишээ нь: Үр дүн, номын хуудас, ганц нэг, хожим хойно, шахаж шаард, нялх балчир, эдийн засаг, хар хээр, шар цоохор , бут ниргэ, зохион байгуул .



## Оюун

Энэ бол хүнд төрөлхөөс заяадаг дотоод хүч. Өөрөөр хэлбэл, хүнийг бусад амьтдаас ялгах мөн чанар юм...

Хүнд төрөлхөөс заяасан оюун хэмээх тайлагдашгүй далд эрчим хүч, мөн чанарыг нээж, хөдөлгөж, тэнхээ чадал суулгахгүй бол харанхуй мунхаг явсаар дуусна. Оюуны мэлмийг нь нээж гал зулыг нь асааж, оч цогийг нь бадрааж, гэрэлтүүлж цацруулж, билиг авьяасынх нь хүчээр тамир тэнхээ оруулж байж л хүн хүншиж, хүмүүжихийн зам мөрд ордог байна...

Хүн аливаа зүйлийг танин мэдэж, ухаарч ойлгосныгоо хэлэндээ тусган илэрхийлдэг. Үүнийг л хэлэн дэх ертөнцийн дүр зураг гэдэг. Тэгвэл оюун хэмээх энэ зүйлийг монголчууд хэлэндээ яаж илэрхийлдгийг товч тайлбарлая.

Оюун хэмээх ухагдахууныг тайлбарлахын тулд ямар ухагдахуунтай холбож сэтгэдгийг хэлний баримтаар жишээлж үзүүлье. Монгол хэлэнд оюун ухаан, оюун бодол, оюун санаа, оюун билэг гэсэн зэрэгцсэн нийлмэл үг тохиолдож байна. Үүнээс үзвэл, оюун нь ухаан, бодол, санаа, билэгтэй учир зүйн ямар нэг холбоотой зүйл байх нь! Монгол хэлэнд зэрэгцсэн нийлмэл үгийн аль нь өмнөө , аль нь ардаа байрлах нь нарийн зүй тогтолтой.

Хэлний баримтаас үзвэл оюун гэдэг үг зэрэгцсэн нийлмэл үгийн бүтцэд бусад үгийн дараа орох нь тун ховор ажээ. Учир нь оюун нь хүнд угаас заяагдмал, тэнгэрлэг, сав шим ертөнцийн шинжтэй.

*Ц. Өнөрбаян. (Нээлттэй сургууль сониноос)*

Зэрэгцсэн нийлмэл үгийн аль нэгийг нь хасаж бичвэл өгүүлбэрүүдийн утгад өөрчлөлт орж байна уу?

## ▣ Дараах үгсийн утга, бүтцийг ажиглая.

(жадан эвэрт, оронго гөрөөс, одос үхэр, арслан заан, тэмээн хяруул, цацагт хяруул, цэн тогоруу, сүт зураг, газар зүйч, чулуун зэвсэг)

- Эсрэг ба ойролцоо утгатай байна уу?
- Хоёр үг нийлж, нэг ухагдахуун, юмыг нэрлэж байна уу?
- Дан дангаараа асуултад хариулагдаж байна уу?
- Хоёр үг нийлж, нэг асуултад хариулагдаж байна уу?
- Зэрэгцсэн нийлмэл үгээс өөр шинжтэй нийлмэл үг байна уу?

Угсарсан нийлмэл үг нь:

- Хоёр үг нийлж, нэг ухагдуухан, юмыг нэрлэдэг.
- Хоёр үг нийлж, нэг асуултад хариулагддаг.
- Бие биенээсээ харилцан хамааралтай бүтдэг.

# Нийлмэл үг



## Зэрэгцсэн нийлмэл үг (Зэрэгцэх холбоогоор)

Хоёр үг харилцан тэгш эрхтэйгээр нийлж бүтсэн үгийг зэрэгцсэн нийлмэл үг \ зэрэгцээ үг\  
Жишээ нь: Эрх чөлөө, эв эе, эрх танхи, эрт орой, хожим хойно, ашиг шим, элбэг дэлбэг , харж ханд

Энгийн зэрэгцсэн нийлмэл үг  
• Эсрэг ба ойролцоо утгатай үг

Давтаж зэрэгцсэн нийлмэл үг  
• Ном зом, хүн мүн,бага сага

## Угсарсан нийлмэл үг (Угсрах холбоогоор)

Хоёр үгийн нэг нь нөгөөдөө угсран захирагдаж бүтсэн үгийг угсарсан нийлмэл үг гэнэ. \ угсраа үг\  
Жишээ нь : морин зөгий, алтан хараацай, эдийн засаг, зүүн урд, усан үзэм, бүтээн босго

Нэг үг нь нөгөөдөө үндсээрээ холбогдож, **хамжсан** угсраа үг бүтнэ.

Нэрийн ба үйлийн холбох нөхцөлөөр холбогдож, **найрсан** угсраа үг бүтнэ.



## Хамжиж угсарсан нийлмэл үг

- Өнгө заасан тэмдэг нэрс жинхэнэ нэртэй холбогдоно. Жишээн: хөх бух, шар шувуу, улаан зээрд, хар халзан, хар хээр
- Таван хошуу малын холбогдолтой жинхэнэ нэр, амьтан, ургамал, зэвсэг хэрэглэл, бодис юмыг заасан жинхэнэ нэртэй холбогдоно. Жишээ нь: морин зөгий, тэмээн хяруул, үхэр чулуу
- Байгалийн нэг бодис юмын нэр нөгөө бодис юмын нэртэй холбогдоно. Жишээ нь: мөнгөн ус, алтан харгана, элсэн чихэр ,хайлуур жонш
- Орон цаг , учир шалтгааны холбогдол бүхий 2 жинхэнэ нэр холбогдоно. Жишээ нь: гар бөмбөг, хөл машин, гэрэл зураг
- Хоёр өөр өнгө, зүс заасан тэмдэг нэр холбогдоно. Жишээ нь: хар хээр, цагаан цэнхэр
- Өнгө зүс заасан тэмдэг нэр өнгө зүсний дээд чанарыг агуулсан юмсын нэртэй холбогдоно. Жишээ нь: ангир шар, үнсэн саарал, дун цагаан, номин цэнхэр, хөө хар гэх мэт .

## Найрч угсарсан нийлмэл үг

- Нэг үг нөгөөтэйгээ харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр холбогдож бүтнэ. Жишээ нь : үхрийн нүд, эдийн засаг, засгийн газар, номын сан, нохойн хошуу, нөгөөдрийн маргааш
- Үйлийн тодотгон холбох нөхцөлөөр холбогдож бүтнэ. Жишээ нь: шинжлэх ухаан, унадаг дугуй, хоргодох байр, дүрслэх урлаг , нисэх буудал, нисдэг тэрэг, буух зурвас, зөвлөх эмч, тэргүүлэх багш гэх мэт .

## Эхээс угсарсан нийлмэл үгийг түүж бичье

Монголын байгаль орчныг хамгаалах нийгэмлэгээс эрхлэн гаргасан “БНМАУ-ын Улаан ном” (Уб, 1987)-д дэлхий дахинаа нэн ховор болж, устах аюулд дөхөөд байгаа цагаан тогоруу, хар тогоруу, цэн тогоруу, жороо тоодог, реликт цахлай, хургач бор хэмээх 6 зүйл, мөн нутгийн ихэнх хэсгээр ховордож байгаа борцгор хотон, халбаган хошуут, хар өрөвтас, гангар хун, хуруут хун, хээрийн галуу, хошуу галуу, явлаг сар, усны цагаан сүүлт бүргэд, цасны хажир, гургуул, тоодог зэрэг 12 зүйл шувуудыг оруулжээ.

*С. Жамбалдорж*

- Эдгээр нийлмэл үгүүд нэг нь нөгөөдөө угсран захирагдаж бүтсэн байна.



Анхаарал тавьсанд  
баярлалаа.

